



МОНГОЛ УЛС  
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 08 сарын 10 өдөр

Дугаар А/986.

Мандалговь

Газар эзэмших эрхийг шилжүүлэх  
тухай

Газрын тухай хуулийн 38 дугаар зүйл 38.1, 38.2, 38.4 дэх заалтууд, газар эзэмших эрхийг шилжүүлэн авах иргэний хүсэлтийг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь :

1. Сайнцагаан сумын 7 дугаар багийн нутаг дэвсгэр (Их тойруу-1, 102 тоот)-т байршилтай иргэн Чойнхор овогтой Алтанцэцэг (ЗК:67072004)-ын амины орон сууцны зориулалттай 188 м.кв (0,01га) газрыг иргэн Алтанцэцэг овогтой Шинэбаяр (ЗЮ:88010172)-т зориулалтаар нь шилжүүлж 21 жилийн хугацаатай эзэмшүүлсүгэй.

2. Дээрх иргэнтэй газар эзэмших гэрээ байгуулж, гэрчилгээ олгохыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга (Э.Чагнаадорж), мөн гэрээний биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газарт, Сайнцагаан сумын Засаг дарга, хотын захирагч (С.Бат-Оргил), аймгийн Мэргэжлийн хяналтын газрын дарга (Ш.Төрбат) нарт үүрэг болгосугай.

3. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2018 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн А/328 дугаар захирамжийн иргэн Ч.Алтанцэцэг-т холбогдох хэсэг мөн газар эзэмших 000025299 тоот гэрчилгээг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.МӨНХБАТ

481210866